



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар Б/11

Хэрлэн сум

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.13 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтийг хамарсан цар тахал ковид-19-тэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангаж, аймгийн Онцгой комисс, Шуурхай штаб, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг удирдан ажилласан аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа Ж.Эрдэнэбатыг аймгийн Засаг даргын өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагналаар шагнахад 910.000 (есөн зуун арван мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх шагналд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Ганбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010367

Аймгийн Засаг даргын 2022 оны
83 дугаар сарын 11 өдрийн
2/11 захирамжийн хавсралт

ШАГНАЛЫН ЗАРДАЛ

| д/д | Зардлын нэр | Тоо | Үнэ | Нийт үнэ | Тайлбар |
|-----|---------------|-----|--------|----------|---------|
| 1 | Өргөмжлөл | 1 | 60000 | 60000 | |
| 2 | Бэлэг дурсгал | 1 | 350000 | 350000 | |
| 3 | Мөнгөн шагнал | 1 | 500000 | 500000 | |
| | | | | 910.000 | |